**БАТЛАВ**

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Б.НАРАНЦЭЦЭГ

**ЧУЛУУНХОРООТ СУМЫН ЕБС-ИЙН 11-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

ВАРИАНТ: А ХУГАЦАА: 80

Ширнэн

Тэр өвгөнийг Ширнэн гэдэг. Миний багад л тийм нэгэн загийн зангилаа шиг хаанаас нь ч өөлөхийн аргагүй бахим хар өвгөн байсан, одоо ч мөн яг л тэр хэвээрээ. Ихэнх хүмүүс залуу зандан үеэ цагийн урсгалд алдчихдаг. Ширнэн тэгсэнгүй. Ширнэн биш Ширмэн юм шиг л байж байдаг юм. Хамаг л шим шүүс, залуу насаа биедээ хураагаад хаячихсан мэт хүн. Төсөөлөн хэлбэл, үндэс, иш, навч найлзуураа дотроо хураачихсан модны үр. Үр үрдээ бүр туулайн бөөр модны үр шиг санагддаг юм.

Ширнэн гуай сүүлдээ манай ажлын газар жижүүр хийдэг болсон юм. Би нэг өдөр гар утсаа хаячихсан юм байлгүй, эрээд эрээд олдоггүй. Цөхрөнгөө бараад Ширнэн гуайгаас асуулаа.

-Хаа холдох вэ дээ, байж л байгаа биз.

-Өрөө тасалгаа, ширээ сандал дээгүүрээ эрээд олдоггүй ээ. Түрүү энд явж байхдаа энэ хавьд хаячихсан байж магадгүй л гэж асууж байгаа юм гэхэд минь,

-Тэгвэл байгаа л биз дээ.

-Байдаггүй ээ, алга болчхож.

-Байгааг нь мэдээд л эрээд байгаа юм байгаа биз дээ.

-Тийм.

-Тэгвэл байгаа биз дээ.

-Байхгүй л байна даа.

-Байхгүй байгаа юм бол байхгүй юмыг чинь ямар юмаа эрдэг юм.

-Уг нь байсан юм шүү дээ.

-Байсан юм бол ямар юмаа харамсдаг юм. Байсан юм бол байж л байгаа гээд огт тоосонгүй. Уур ч хүрэх шиг, инээд ч хүрэх шиг болов. Миний байдлыг мэдсэн янзтай,

-Байгаа юмыг байна гэж хөөрцөглөхгүй, байхгүй юмыг алга гэж харамсахгүй байж чадвал амар байдаг юм даа гэхэд нь би, юу гэх нь вэ гэж бодоод,

-Та баян хүн үү? гэлээ. Ширнэн гуай надруу харж,

-Надад баян хоосон сайхан муухай ялгаа байдаггүй юм гээд дуугүй болов. Яг л туулайн бөөр модны үр шиг ...

**1.** Би баатар хэдийгээр гар утсаа олоогүй ч өөрт тусгах чухал зүйлсийг Ширнэнгээс олж харсан нь юу вэ? Өөрийн үгээр тайлбарлан бичээрэй. \4 оноо\

........................................................................................................................................................
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
..............................................................................................

2. “Толгод хүүхэд адил өсөж, толгод хүүхэд адил олширч, үдшийн цагаан гэгээнд хөөцөлдөн эрхлэлдэхийг ажихуй энэ яваа насны учир утга, амьдрахуйн хүслэн тодорно.” гэсэн өгүүлбэрийн утга, бүтэц, үүргийг тодорхойлоорой. \4 оноо\

........................................................................................................................................................
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
..............................................................................................

3. Тэд халуун элгэн нутгаа дуула**н**, аньсага нь чийгтэ**ж**, сэтгэл уяр**ч**, зүрхэндээ омогшдог юм гэсэн өгүүлбэрийн тодруулсан бүтээврийг ойролцоо утгат бүтээврээр солин найруулна уу?

........................................................................................................................................................
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
........................................................................................................................................................
..............................................................................................

4. Дараах холбоо үгийн зүй тогтлыг ажиглаад, цэгийн оронд тохирохыг сонono уу?
Баян чинээлэг, үр тариа, нарсны төөлүүр, зөгийн бал , найр хурим, ..........................
А. Цэцгийн үр Б. Эмнэг хангал В. Моносны үр

5. Дараах үгсийг зөв бичгийн дүрэмтэй нь зөв харгалзуулаарай.

| | |
|---|---|
| 1. Эгшиг зохицох ёсны дагуу эр үгэнд "-ы", эм үгэнд "-ий" залгана. | А. Сургуулийн, байгалийн, хуулийг |
| 2. Эр үг ж,ч,ш-ээр төгссөн бол эм үгийн –ийн, -ийг бичнэ. | Б. Сангийн, байшингийн, савангийн |
| 3. Эр үг хэлний г-ээр төгссөн бол эм үгийн ий бичнэ. | В. хуягийг, хоногийн, цагийн |
| 4. Эр үг ь-ээр төгссөн бол "-ий" бичнэ. | Г. Даргын, хөгжлийн, өргөмжлөлийг |
| 5. Давхар зөөлөрсөн гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд эм үгийн "-ий" бичнэ. | Д. Багшийг, багажийг, жолоочийн |

**6. "ж,ч,ш-ээс бусад эгшгийн дараа орсон зөөлрүүлэх үүрэгтэй "-и" эгшгийг гээхгүй." гэсэн дүрэмд тохирох хариултыг олно уу?**
А. танилыг, ярихаар, сонины б. тамирын, амины, хасах в. бохироос, багажаа, саналаар

## Хоёрдугаар хэсэг: Уран зохиол

1. Зохиолыг шүлгийн хэсэгтэй нь зөв харгалзуулна уу? 2 оноо

1. Чиний явах сайн замыг, уул чамдаа зааж өгье би
Чихэнд шингээж захих үгээ дараагаар нь хэлж өгье
2. Үхэх төрөхийн утга учир оньсого мэт
Үзтэл мэргэд утга учрыг нь олж чадсангүй
3. Аймшигт ядуу эр
Амуу цайруулахаа болиод
Онгон сарыг ширтэв.
4. Удам угсаа сайтынх – төлөв даруухан
Ухаан оюун саруулынх – сэтгэл ариухан

а. Омар Хайям "Рубай"
б. Франческо Петрарка "Сонет"
в. Мацуо Башё "Хайку"
г. Галидас "Үүлэн зардас"

2. Дараах туульсыг улсуудтай нь зөв харгалзуулсныг сонгоорой.

| | |
|---|---|
| 1. Мянга нэгэн шөнийн үлгэр | а. Монгол |
| 2. Игорийн хорооны үг | б. Хятад |
| 3. Тансан ламын үлгэр | в. Араб |
| 4. Гэсэр, Жангар | г. Орос |
| 5. Илиада, Одиссей | д. Грек |

А. 1б2г3в4а5д б. 1в2г3б4а5д в. 1в2г3б4д5а г. 1г2в3б4а5д

3. Хувь хүний давтагдашгүй зан чанар, бусдаас ялгагдах өвөрмөц шинжтэй дүрийг ямар дүр гэх вэ?
А. Нийтлэг дүр б. бодгаль дүр в. гадаад төрх г. дотоод шинж

## Гуравдугаар хэсэг: Үндэсний бичиг

**Дараах эхийг кирил бичигт буулгана уу? 5 оноо**



**Дөрөвдүгээр хэсэг: Эх зохион найруулах**

*“**Манай дэлхий миний нүдээр**”* сэдвээр \200-250\ үгэнд багтаан эх зохион бичээрэй. өөрийн үзэл бодолтой холбон олон талаас нь эргэцүүлэн бичихдээ баримт, тайлбар ашиглан, орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэн эх зохион бичнэ үү. \20 оноо\

**Эхлэл хэсэг :** - Эх дэлхийн талаар сэтгэгдлээ бичих

**Гол хэсэг :** - Эх дэлхийгээ хайрлан хамгаалахад өөрийн оруулах хувь нэмрээ дэлгэрүүлэн бичих.

**Төгсгөл хэсэг :** - Ирээдүйд эх дэлхий маань ийм байгаасай гэсэн өөрийн үзэл бодлоо бусдад үлгэр дуурайлал болохуйц байдлаар бичиж

**БАТЛАВ**

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Б.НАРАНЦЭЦЭГ

**ЧУЛУУНХОРООТ СУМЫН ЕБС-ИЙН 11-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

ВАРИАНТ: В ХУГАЦАА: 80

ТААХАГ

Энэ буурыг "Таахаг" хэмээнэ. Ямагт сvргийнхээ араас таахаг, таахаг алхлан, тайван явдаг энэ лагс том буур сvvлийн vед юу болов гэмээр айхавтар догширдог болжээ. Хvнээр бол зан ааш нь жигтэйхэн эвдэрсэн гэмээр харагдана. Хавьд чоно нохой сvрэгт нь халдаагvй, айл саахалтын буууртай "урцалдаагvй" атал юунд галзуурсан мэт хэдэн ингээ хаа гуягvй хазаж хавиран, ботго тормоо хvртэл борвидох нь халаг хvзvv сунган хаашаа ч хамаагvй элдэж явдаг зантай болчихдогсон билээ? Үнэндээ гэхэд тvvний зан ааш ингэтлээ гэнэт хувирсныг эзэн нь огт тєсєєлж мэдэхгvй бєгєєд гагцхvv "Таахаг"-т vл таалагдах хvний нэг хачирхалтай vйл явдал, ой гутам нялуун vнэр хоёроос уг явдал vvдэлтэйг ч хvмvvс анхаарсангvй.

Єнєє єглєє ч гэсэн буур ижил сvргээ зэлнээс шалав холдуулъя гэсэн мэт, vнсэн дээр хєрвєєх гэж явсан ингэ голдуу баахан тэмээгээ буцаан хєєж, бусдыг хэвтрээс нь босгоод хэдгэнэ шиг хэрэн элдсээр бэлчээр тийш туун одвой. Буур бvхэнд, тэр тусмаа хvний ухааныг ямар нэг хэмжээгээр авсан байж болзошгvй гэцгээдэг нь эртний Галзуу улаан, Гялбаа хvрэн, Тэнгэр дуут, Их тавхайтын удам -Таахаг нэрт энэ буур єєрийн тєрєлх зєнгєєс л болоод ороогоо орох болоогvй байхад хvч тэнхээгээ бартал ийнхvv догшроход хvрчээ. Үvнээс vзвэл ер тvvнийг зvгээр л нэг буур тєдийгєє ухаарч боломгvй санагдана. Алив эцэг малд байдаг сvрлэг омгорхуу, догшин ээзрхэг зантайгаас гадна тvvнд єших, ємєєрєх. хямрах ааш араншин бий гэдэг нь илэрхий! Чухам vvнийгээ бусад буурнаас тодорхой харуулж чаддаг чанараараа Єргєний говьд гайхагддаг байж ч болзошгvй.

...Тийнхvv Таахаг сvргээ чимх євс хазуулсангvй шахам хашин хєєсєєр бага vдийн алдад Хvрэн тойром хvрч, тэндээсээ эргvvлж элдэх замдаа нэгэн хот айлын гадаа хvрч ирлээ. Явдалдаа ядарч сульдсан тэмээд хvнд хєл, лагс биеийнхээ чилээг гарахаар мєнєєхєн айлын vнсэн дээр хэвтэж амрах, хєрвєєж "жаргахаар" хошууран цувахад буур ч дургvйлхсэнгvй. Таахаг энэ сацуу хачин жигтэй юм харлаа. Бєєренхий цагаанаас (гэрээс) хэдэн хvн гарч ирээд нэгэн тэмээг ноолж эхлэхийг узэв. Ноос vсийг нь мулзалж авахтай эгээ адилхан хэвтvvлээд татлага дээсээр баглан хvлж, урт хvзvvг нь газартай наалдуулан сунгаж, хэн нэгэн нь ямарваа шовх юмаар (хvмvvс тvvнийг хутга гэнэ) шилэн хvзvv рvv нь дvрээд авсанд жигтэй нялуун vнэр ханхийжээ. Тэмээ босохыг завдан бvх биеэр єндєсхийснээ тєдєлгvй хєдлєхєє болихыг буур сайтар харсан аж.

Эвгvй vнэр авсан тэмээд vнсэн дээрээсээ зэрэг дэрхийн босч чих босгон, хамар шуухируулан, бага залуу нь vнс бужигнатал дэвслэх нь vргэн зайлахыг завдан буйн тэмдэг болой. Тийн хэсэг байзнатал мєнєєхєн хvмуvс яах ийхийн завдалгvй нєгєє тэмээний арьсыг хуулж, эхлээд нvцгэн цагаан бєх, дараа нь улаан махыг гаргасанд Таахагийн тэсвэр тэвчээр алдагдан даруй хурдан зайлахаас аргагvй болов.

...Ийм юмыг урьд ємнє vзэх ч аргагvй байжээ. Юу гэвэл монгол хvн ямарваа малыг муулахдаа тvvнийг сvргийн нvднээс нуудаг тэгээд ижил сvргийг бэлчээрт гаргасан хойно эд бад хийдэг заншилтай. Хэрвээ эл хот айлынхан заншил ёс мэддэгсэн бол vнсэн дээрээ тэмээ ирэхэд дав даруй хєєж зайлуулах л байсан биз ээ! Гэтэл тэгсэнгvй.

Таахаг дотор эрхтэнээ гулгин гаргахаас наахнуур сvргээ хєєсєєр хот айлаас холдтол ємнєєс нь нєгєє муухай vнэр дахиад л тосон угтлаа. Сvргээ арга буюу эргvvлэхэд хvрэв. Тэгтэл урдаас нь цус, сэвсний нялуун vнэр улам ч хvчтэй цоргив. Тэгэхээр нь сvргээ баруун зvг эргvvлэв. Дахиад л vнэр! Зvvн тийш туулаа. Үнэр! Урагшаа, хойшоо Үнэр!

Буур хэдий тэнхээтэй, бас ухаантай гэгдэх боловч хvн гэгч амьтнаас сvргээ хэрхэн яаж ємгєєлж хамгаалж чадахсан билээ дээ?

/С.Надмид "Таахаг" өгүүллэгээс/

1. Зохиолд ямар ёс зан заншлыг мэдүүлэхийг зорьсон бэ? Жишээ баримтаар тайлбарлана уу? \4 оноо\
.....................................................................................................................................................
.....................................................................................................................................................
.....................................................................................................................................................
.....................................................................................................................................................
................
2. Дараах өгүүлбэр хэдэн энгийн өгүүлбэрээс бүтсэнийг задлан тайлбарлаад, тодорхойлно уу? \4 оноо\
Ноос vсийг нь мулзалж авахтай эгээ адилхан хэвтvvлээд татлага дээсээр баглан хvлж, урт хvзvvг нь газартай наалдуулан сунгаж, хэн нэгэн нь ямарваа шовх юмаар шилэн хvзvv рvv нь дvрээд авсанд жигтэй нялуун vнэр ханхийжээ.

.......................................................................................................................................................
.......................................................................................................................................................
.......................................................................................................................................................
.......................................................................................................................................................
................

3. Тал уужир**ч**, тариа долгиоло**н**, трактор комбайн хүнгэнэ**н**, ажил өрнөхөөр хүн бүр баяртай гэсэн өгүүлбэрийн тодруулсан бүтээврийг ойролцоо утгат бүтээврээр солин найруулна уу?

.......................................................................................................................................................
.......................................................................................................................................................
.......................................................................................................................................................
.......................................................................................................................................................
................

4. Найрах аргаар холбогдсон холбоо үгийг зөв бүлэглэсэн үгсийг олоорой.

А. Хүйсийн говь, нарийн хоолой
Б. Хэдэн мал, хүний хэл
В. Тэмээгээр дүүргэх, малтайгаа ярих

5. Дараах эхийн хэсгийг уншаад даалгарвыг гүйцэтгээрэй.

Зургийн сайхныг зураачийн эрдэм чадлаар бүтээнэ. Зурсан хөргийг “амьд юм шиг” гэх буюу “зургийн чононд нохой хуцна” гэдэг бол зураачийн чадал эрдмийг үнэлсэн домог юм. Зураач урлах эрдмээ сайжруулсанаар домгийн тэр чадлыг олно. Тийм зураачийн бүтээлийн урныг гайхмаар.

| Эр үгэнд “-ы” залгана. | Эм үгэнд “-ий” залгана. | ж,ч,ш төгссөн эр үгэнд “-ий” бичнэ. | Хэлний г-ээр төгссөн эр үгэнд “-ий” бичнэ. |
|---|---|---|---|
| | | | |

**6. “ж,ч,ш-ээс бусад эгшгийн дараа орсон зөөлрүүлэх үүрэгтэй “и” эгшгийг гээхгүй.” гэсэн дүрэмд тохирох хариултыг олно уу?**

А. танилыг, ярихаар, сонины б. тамирын, амины, хасах в. бохироос, багажаа, саналаар

## Хоёрдугаар хэсэг: Уран зохиол

1. Альфонс Доде Сүүлчийн хичээл өгүүллэгт гарч буй үйл явдлуудыг зөв дараалалд оруулсан хэсгийг сонгоно уу?

1. Өнөөдөр Франц хэлний сүүлчийн хичээл.
2. Хэлзүйн хичээлийн дараа бичгийн ажил эхлэв.
3. Би энэ сүүлчийн хичээлийг мартахгүй.
4. Ринерийн нугад болон ойн захаар хөөндэйн жиргэх дуун сонсогдоно.

А. 4, 1,2,3 б. 4,2,1,3 в. 1,2,4,3 г. 2,1,4,3

2. Махабхарата тууль нь ямар үйл явдлаар эхэлдэг вэ?

А. Куругийн гэр бүл хэрхэн Каурынхан, Пандугийнхан болсон тухай
Б. Юдхиштра болон Дүрёдхана хоёрын хоорондох зөрчил тэмцлийн тухай
В. Энэтхэгийн их хаан Бхаратын удмын хаадын уг гарал, түүхэн амьдралаар
Г. Пандугийнхан диваажинг зорин, урт аялалд гарч буйгаар

3. Оросын ард түмний гайхамшигт бүтээл болох”Игорийн хорооны үг” туульд **Игорь вангийн хүч чадлыг** ямар дүрслэх ур маягаар илэрхийлсэн байна вэ?

А. Төлөөлөл б. багасгал в. хэтрүүлэл г. ёгтлол

## Гуравдугаар хэсэг: Үндэсний бичиг

**Дараах эхийг кирил бичигт буулгана уу? 5 оноо**



**Дөрөвдүгээр хэсэг: Эх зохион найруулах**

**“Ирээдүйн миний монгол**” сэдвээр 200- 250 үгэнд багтаан эх зохион бичээрэй. өөрийн үзэл бодолтой холбон олон талаас нь эргэцүүлэн бичихдээ баримт, тайлбар ашиглан, орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэн эх зохион бичнэ үү.

\20 оноо\

**Эхлэл хэсэг :** - өнөөдрийн монгол улсын хөгжлийн талаар сэтгэгдлээ нээж эхлэх

**Гол хэсэг :** - улс орноо хөгжүүлэхэд бид өөрсдөө яаж оролцох талаар дэлгэрүүлэн бичих.

**Төгсгөл хэсэг :** - ирээдүйд Монгол улс маань иим болоосой гэсэн үзэл бодлоо бусдад уриалан таниулах байдлаар бичиж төгсгөх